

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/																																	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.																																	
Тайлагнах хугацаа	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 28 өдөр																																
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК УБГД:000267784 Хувийн хэргийн дугаар:9012001021 ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747</p>																																
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ХК																																
Бизнесийн үйл ажиллагааны салбар	66110-Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага 66190- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа																																
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	350,463,539 ширхэг																																
Хагас жилийн тайланыг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: Д.Нарангэрэл /Ерөнхий нягтлан/ А.Солонго /Стратеги төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн/</p> <p>Хянасан: Г.Тэмүүжин /ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга/</p>																																
1. Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th><th>1/1/2024</th><th>06/28/2024</th></tr> </thead> <tbody> <tr> <td align="center">ХӨРӨНГӨ</td><td></td><td></td></tr> <tr> <td>Эргэлтийн хөрөнгө</td><td>904,842,895,157.05</td><td>1,061,566,117,311.11</td></tr> <tr> <td>Эргэлтийн бус хөрөнгө</td><td>22,452,015,473.10</td><td>22,163,452,442.64</td></tr> <tr> <td>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</td><td>927,294,910,630.15</td><td>1,083,729,569,753.75</td></tr> <tr> <td align="center">ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</td><td></td><td></td></tr> <tr> <td>Богино хугацаат өр төлбөр</td><td>881,588,538,249.72</td><td>1,024,570,003,695.24</td></tr> <tr> <td>Урт хугацаат өр төлбөр</td><td>1,626,561,592.92</td><td>1,583,107,263.63</td></tr> <tr> <td>Эздийн өмчийн дүн</td><td>44,079,810,787.51</td><td>57,576,458,794.88</td></tr> <tr> <td>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</td><td>927,294,910,630.15</td><td>1,083,729,569,753.75</td></tr> </tbody> </table>			Үзүүлэлт	1/1/2024	06/28/2024	ХӨРӨНГӨ			Эргэлтийн хөрөнгө	904,842,895,157.05	1,061,566,117,311.11	Эргэлтийн бус хөрөнгө	22,452,015,473.10	22,163,452,442.64	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	927,294,910,630.15	1,083,729,569,753.75	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			Богино хугацаат өр төлбөр	881,588,538,249.72	1,024,570,003,695.24	Урт хугацаат өр төлбөр	1,626,561,592.92	1,583,107,263.63	Эздийн өмчийн дүн	44,079,810,787.51	57,576,458,794.88	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	927,294,910,630.15	1,083,729,569,753.75
Үзүүлэлт	1/1/2024	06/28/2024																															
ХӨРӨНГӨ																																	
Эргэлтийн хөрөнгө	904,842,895,157.05	1,061,566,117,311.11																															
Эргэлтийн бус хөрөнгө	22,452,015,473.10	22,163,452,442.64																															
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	927,294,910,630.15	1,083,729,569,753.75																															
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ																																	
Богино хугацаат өр төлбөр	881,588,538,249.72	1,024,570,003,695.24																															
Урт хугацаат өр төлбөр	1,626,561,592.92	1,583,107,263.63																															
Эздийн өмчийн дүн	44,079,810,787.51	57,576,458,794.88																															
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	927,294,910,630.15	1,083,729,569,753.75																															
Орлогын тайлан	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th><th>1/1/2024</th><th>06/28/2024</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Борлуулалтын орлого (цэвэр)</td><td>16,709,471,639.67</td><td>23,933,444,561.53</td></tr> <tr> <td>Борлуулалтын өртөг</td><td></td><td></td></tr> <tr> <td>Нийт ашиг (алдагдал)</td><td>16,709,471,639.67</td><td>23,933,444,561.53</td></tr> <tr> <td>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</td><td>10,337,515,816.10</td><td>19,830,583,412.04</td></tr> <tr> <td>Орлогын татварын зардал</td><td>1,029,799,778.87</td><td>1,984,721,003.55</td></tr> </tbody> </table>			Үзүүлэлт	1/1/2024	06/28/2024	Борлуулалтын орлого (цэвэр)	16,709,471,639.67	23,933,444,561.53	Борлуулалтын өртөг			Нийт ашиг (алдагдал)	16,709,471,639.67	23,933,444,561.53	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	10,337,515,816.10	19,830,583,412.04	Орлогын татварын зардал	1,029,799,778.87	1,984,721,003.55												
Үзүүлэлт	1/1/2024	06/28/2024																															
Борлуулалтын орлого (цэвэр)	16,709,471,639.67	23,933,444,561.53																															
Борлуулалтын өртөг																																	
Нийт ашиг (алдагдал)	16,709,471,639.67	23,933,444,561.53																															
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	10,337,515,816.10	19,830,583,412.04																															
Орлогын татварын зардал	1,029,799,778.87	1,984,721,003.55																															

	<p>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) Бусад дэлгэрэнгүй орлого Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү Орлогын нийт дүн</p>	9,307,716,037.23	17,845,862,408.49																																									
		Үзүүлэлт	1/1/2024																																									
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл Эздийн өмчийн бусад хэсэг Хуримтлагдсан ашиг Нийт эздийн өмчийн дүн	35,046,353,900.00 20,021,146,332.29 446,321,902.02 (11,434,011,346.80) 44,079,810,787.51	35,046,353,900.00 20,021,146,332.29 446,321,902.02 2,062,636,660.57) 57,576,458,794.88																																									
		Үзүүлэлт	06/28/2024																																									
Mөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ Бүх цэвэр мөнгөн гүйлгээ Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	896,919,408,256.00 (575,344,268.00) 11,915,759,800.00 900,851,104,693.72 1,731,709,823.19 902,582,814,516.91	168,482,851,590.88 (393,855,487.00) - 157,313,641,232.25 902,582,814,516.91 1,059,896,455,749.16																																									
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт																																											
	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо нь 2024 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн эхний хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэсэн болно.																																											
3.	Tайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт																																											
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2019</th> <th>2020</th> <th>2021</th> <th>2022</th> <th>2023-II</th> <th>2023</th> <th>2024-II</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Нийт ашгийн хувь</td> <td>100%</td> <td>100%</td> <td>100%</td> <td>100%</td> <td>100%</td> <td>100%</td> <td>100%</td> </tr> <tr> <td>Цэвэр ашгийн хувь</td> <td>-77%</td> <td>-94%</td> <td>58%</td> <td>15%</td> <td>42%</td> <td>77%</td> <td>206%</td> </tr> <tr> <td>Өөрийн хөрөнгийн өгөөж</td> <td>-51%</td> <td>-82%</td> <td>72%</td> <td>3%</td> <td>6%</td> <td>21%</td> <td>31%</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн өгөөж</td> <td>-30%</td> <td>-30%</td> <td>59%</td> <td>3%</td> <td>2%</td> <td>1%</td> <td>2%</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023-II	2023	2024-II	Нийт ашгийн хувь	100%	100%	100%	100%	100%	100%	100%	Цэвэр ашгийн хувь	-77%	-94%	58%	15%	42%	77%	206%	Өөрийн хөрөнгийн өгөөж	-51%	-82%	72%	3%	6%	21%	31%	Нийт хөрөнгийн өгөөж	-30%	-30%	59%	3%	2%	1%	2%		
Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023-II	2023	2024-II																																					
Нийт ашгийн хувь	100%	100%	100%	100%	100%	100%	100%																																					
Цэвэр ашгийн хувь	-77%	-94%	58%	15%	42%	77%	206%																																					
Өөрийн хөрөнгийн өгөөж	-51%	-82%	72%	3%	6%	21%	31%																																					
Нийт хөрөнгийн өгөөж	-30%	-30%	59%	3%	2%	1%	2%																																					

		<table border="1"> <thead> <tr> <th>Год</th> <th>Цэвэр ашгийн хувь</th> <th>Нийт хөрөнгийн өгөөж</th> <th>Нийт ашгийн хувь</th> </tr> </thead> <tbody> <tr><td>2019</td><td>-10%</td><td>-10%</td><td>-10%</td></tr> <tr><td>2020</td><td>-10%</td><td>-10%</td><td>-10%</td></tr> <tr><td>2021</td><td>50%</td><td>50%</td><td>50%</td></tr> <tr><td>2022</td><td>10%</td><td>10%</td><td>10%</td></tr> <tr><td>2023-II</td><td>30%</td><td>10%</td><td>30%</td></tr> <tr><td>2024-II</td><td>120%</td><td>20%</td><td>120%</td></tr> </tbody> </table>	Год	Цэвэр ашгийн хувь	Нийт хөрөнгийн өгөөж	Нийт ашгийн хувь	2019	-10%	-10%	-10%	2020	-10%	-10%	-10%	2021	50%	50%	50%	2022	10%	10%	10%	2023-II	30%	10%	30%	2024-II	120%	20%	120%																																
Год	Цэвэр ашгийн хувь	Нийт хөрөнгийн өгөөж	Нийт ашгийн хувь																																																											
2019	-10%	-10%	-10%																																																											
2020	-10%	-10%	-10%																																																											
2021	50%	50%	50%																																																											
2022	10%	10%	10%																																																											
2023-II	30%	10%	30%																																																											
2024-II	120%	20%	120%																																																											
3.2.	Хөрөнгийн санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2019</th> <th>2020</th> <th>2021</th> <th>2022</th> <th>2023-II</th> <th>2023</th> <th>2024-II</th> </tr> </thead> <tbody> <tr><td>Эргэлтийн харьцаа</td><td>0.67</td><td>0.31</td><td>3.05</td><td>2.30</td><td>1.26</td><td>1.03</td><td>1.04</td></tr> <tr><td>ТТГЧадварын харьцаа</td><td>0.65</td><td>0.30</td><td>3.03</td><td>2.27</td><td>1.26</td><td>1.03</td><td>1.04</td></tr> <tr><td>Өр, эздийн өмчийн харьцаа</td><td>0.73</td><td>1.75</td><td>0.21</td><td>0.08</td><td>1.61</td><td>20.04</td><td>17.82</td></tr> </tbody> </table> <table border="1"> <thead> <tr> <th>Год</th> <th>Эргэлтийн харьцаа</th> <th>ТТГЧадварын харьцаа</th> <th>Өр, эздийн өмчийн харьцаа</th> </tr> </thead> <tbody> <tr><td>2019</td><td>1.0</td><td>1.0</td><td>1.0</td></tr> <tr><td>2020</td><td>2.0</td><td>1.0</td><td>1.0</td></tr> <tr><td>2021</td><td>1.0</td><td>3.0</td><td>1.0</td></tr> <tr><td>2022</td><td>1.0</td><td>2.0</td><td>1.0</td></tr> <tr><td>2023-II</td><td>2.0</td><td>1.5</td><td>2.0</td></tr> <tr><td>2024-II</td><td>18.0</td><td>1.5</td><td>18.0</td></tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023-II	2023	2024-II	Эргэлтийн харьцаа	0.67	0.31	3.05	2.30	1.26	1.03	1.04	ТТГЧадварын харьцаа	0.65	0.30	3.03	2.27	1.26	1.03	1.04	Өр, эздийн өмчийн харьцаа	0.73	1.75	0.21	0.08	1.61	20.04	17.82	Год	Эргэлтийн харьцаа	ТТГЧадварын харьцаа	Өр, эздийн өмчийн харьцаа	2019	1.0	1.0	1.0	2020	2.0	1.0	1.0	2021	1.0	3.0	1.0	2022	1.0	2.0	1.0	2023-II	2.0	1.5	2.0	2024-II	18.0	1.5	18.0
Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023-II	2023	2024-II																																																							
Эргэлтийн харьцаа	0.67	0.31	3.05	2.30	1.26	1.03	1.04																																																							
ТТГЧадварын харьцаа	0.65	0.30	3.03	2.27	1.26	1.03	1.04																																																							
Өр, эздийн өмчийн харьцаа	0.73	1.75	0.21	0.08	1.61	20.04	17.82																																																							
Год	Эргэлтийн харьцаа	ТТГЧадварын харьцаа	Өр, эздийн өмчийн харьцаа																																																											
2019	1.0	1.0	1.0																																																											
2020	2.0	1.0	1.0																																																											
2021	1.0	3.0	1.0																																																											
2022	1.0	2.0	1.0																																																											
2023-II	2.0	1.5	2.0																																																											
2024-II	18.0	1.5	18.0																																																											
3.3.	<p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> Үнэт цаасны арилжаа: Дотоодын үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индекс 2024 оны эхний хагас жилд 45,024.07 нэгжид хүрч өссөн бол доод үзүүлэлт нь 40,704.45 нэгж, дундаж үзүүлэлт нь 42,940.88 нэгж байсан бол энэ оны 6 дугаар сарын 28-ны байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,486.02 нэгж буюу 20.29 хувиар өсөж, 44,385.18 нэгж болсон байна. Зах зээлийн үнэлгээ 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 11.28 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 288.11 тэрбум төгрөг буюу 2.62 хувиар өссөн байна. Харин үнэт цаасны арилжааны хувьд, 2024 оны эхний хагас жилд нийт 125 удаагийн нийт 797.08 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулсан байна. Тодруулбал, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 136 хувьцаат компанийн 773,76 сая ширхэг хувьцааг 184.7 тэрбум төгрөгөөр, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 490.76 мянган ширхэг үнэт 																																																												

цаасыг 44.43 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 5.38 сая ширхэг нэгж эрхийг 2.92 тэрбум төгрөгөөр, компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 5.67 сая ширхэг бондыг 565.03 тэрбум төгрөгөөр тус тус арилжааллаа.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 6.28 сая ширхэг үнэт цаасыг 6.37 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Нийт арилжаа өмнөх оны мөн үеэс 1.55 дахин өссөн байна.

- Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа:
2024 оны эхний хагас жилд нийт 339 удаагийн УУБ-ий цахим дуудлага арилжаа зохион байгуулсан.

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан “Эрдэнэс таван толгой” ХК, “Тавантолгой” ХХК, “Энержи ресурс” ХХК, “Хангад эксплорэйшин” ХХК, “Монгол Алт (МАК)” ХХК нь 14.55 сая тонн нүүрсийг 5.87 их наяд төгрөгөөр, “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 980.1 мянган тонн төмрийн хүдэр болон баяжмалыг 241.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан.

Харин энэ оны 4 дүгээр сараас зэсийн баяжмалын арилжааг эхлүүлсэн “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ нь 6.0 мянган тонн зэсийн баяжмалыг 40.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан бол энэ оны 6 дугаар сард анх удаа “Монголросцветмет” ТӨҮГ нь нийт 4.3 мянган тонн хайлуур жоншины баяжмалыг 5.3 тэрбум төгрөгөөр арилжаалсан.

- Шинэ бүтээгдэхүүн:
Тайлант хугацаанд “Ард кредит ББСБ” ХК нэмж хувьцаа гарган 8.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бол “Эм Жи Эл Акуа” ХК хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгон нээлттэй компани болж 15.3 тэрбум төгрөг татан төвлөрүүллээ.

Өрийн хэрэгслийн хувьд, “Бэрс Эй Би Эс Лоялти ТЗК” ХХК-ийн 35.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 350,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, “Ашид Капитал ББСБ” ХХК-ийн 20.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 200,000 ширхэг бонд, болон Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд 500.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 5,000,000 ширхэг бондын анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулав.

2024 оны 6 дугаар сарын 28-ны байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр 171 хувьцаа, 12 компанийн бонд, 2 хөрөнгө оруулалтын сан, 9 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлтэй байна.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга:
УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталсан.

Тус хуульд Хувьцааны хамтын санхүүжилт, Банкны хадгаламжийн сертификат гаргах, Олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл, Хаалттай ХК-ийн хувьцааг биржээр арилжаалах, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан.

	<p>Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, МУЦАЭХ-ноос холбогдох харилцааг зохицуулах 10 гаруй журмыг шинээр болон шинэчлэн батлах эрх үүссэн бөгөөд тус журмууд батлагдсанаар шинэ бүтээгдэхүүн, үлчилгээ нэвтрэх эрх зүйн зохицуулалт бүрдэх юм.</p> <ul style="list-style-type: none"> Зах зээлийн өөрчлөлттэй уялдуулан Биржээс авч хэрэгжүүлэхээр төлөөвлөж буй арга хэмжээ: <p>Нээлттэй хувьцаат компани болох зорилгоор хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэж, хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгож, тэдгээрийн хооронд арилжих нөхцөлийг энэ онд багтаан бүрдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Дараагийн тайлант хугацаанд ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд тавигдах бүртгэлийн шалгуур, шаардлагыг багасгах чиглэлээр “Үнэт цаасны бүртгэлийн журам”, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор “Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.</p> <p>Түүнчлэн, 2024 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн зах зээл болон уул уурхайн бүтээгдэхүүнийг гадаад улсуудад сурталчлах, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Бээжингийн хөрөнгийн бирж болон АНУ-ын Чикагогийн таваарын биржтэй албан уулзалт зохион байгуулж, бирж хоорондын хамтын ажиллагааны боломжийн талаар санал солилицон, цаашид хамтран ажиллахаар боллоо.</p> <p>Цаашид гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдыг Монголын санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцох боломж нөхцөлийг нэмэгдүүлэх, үнэт цаас зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, оролцогч байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулах зорилт тавин ажиллаж байна.</p>
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл
	Хавсралт 1-ийг үзнэ үү.
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг. ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй.

Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор 11 удаа хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Компанийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”- аар тус тус зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.
- Эрсдэл (комплаенс)-ын удирдлагын хороо

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршилагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохицтой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар З жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Иймд энэ оны хагас жилийн байдлаар 2023 онд томилогдсон Д.Тогтохбаяр, Ж.Цогтбаяр, Ж.Бямбасүрэн, Т.Ганбаатар, С.Баянцогт, Р.Мөнхтөр, Н.Улаанхүү, Н.Отгончимэг, М.Банзрагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2023 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2023 оны 05 дугаар сард шинээр томилсон ба 2024 оны эхний хагас жилийн байдлаар өөрчлөлтгүй байна.

7. Унэт цаас гарагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ТУЗ нь 2024 оны эхний хагас жилд Компанийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хувиарлах, Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Унэт цаасны

арилжаатай холбоотой журам батлах, Уул уурхай, Үнэт цаасны арилжааны брокерт гишүүнчлэл олгох, Дахин үнэлэх, актлах хөрөнгийн талаар дүгнэлт гаргах зэрэг нийт 40 асуудлыг хэлэлцэж, 42 шийдвэр гаргасан. Үүнээс 22 тогтоолоор өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн, 3 тогтоол бүрэн бус хэрэгжсэн байна. 14 тэмдэглэлээр өгсөн үүрэг 100% хэрэгжилттэй байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Ж.Цогтбаяр

Албан тушаал: "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын үргийг түр орлон гүйцэтгэгч

Гарын үсэг: 

(Тамга/тэмдэг)



“Монголын хөрөнгийн бирж” ХК



Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжин нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Үнэт цаасны танилцуулагад тусгасны дагуу компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн.

№ Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	
1	Арилжааны систем сайжруулалт
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох
Нийт	
	100.0%

Компани 2024 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 5.4 тэрбум төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөсөн. Үүнд:

- Мэдээлэл технологийн шинэчлэл сайжруулалт буюу серверийн өрөөний өргөтгөл, стандартжуулалт болон дотоод үйл ажиллагааны цахимжуулалтад нийт 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

- Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход 2.2 тэрбум төгрөг, арилжааны системийн сайжруулалтад 1.9 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулахаар төлөвлөсөн болно. Арилжааны системийн сайжруулалтад зориулах 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтад MIT арилжааны болон хяналтын программ хангамжийн шинэчлэл, MIT үйлдлийн системийн шинэчлэл, түүхий эд болон деривативын арилжааны модуль багтсан болно.

Үүнээс 2024 оны 2 дугаар улирлын байдлаар Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын ажилд 2.1 тэрбум төгрөг, Серверийн өрөөний өргөтгөл, стандартжуулалтын ажилд 1.03 тэрбум төгрөг, Дотоод үйл ажиллагааны цахимжуулалтад 38.5 сая төгрөг, арилжааны системийн сайжруулалт буюу Нөөц төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт, системийн тохиргоо, Систем дээр хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн ажилд 44.2 сая төгрөг, нийт 3.2 тэрбум төгрөгийн хөрөнгө

оруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгө зарцуулалтын 2024 оны 2 дугаар улирлын тайланг танилцуулвал.

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	/мянган төгрөг/								
		Гүйцэтгэл 2023.12.31	Гүйцэтгэл 2024.06.30	Нийт зарцуулалт						
1	Арилжааны систем сайжруулалт	7,590,339.31	63.70%	1,264,996.97	10.60%	44,276.48	0.40%	1,309,273.45	10.90%	
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986.35	10.70%	65,896.31	0.60%	1,026,000	8.60%	1,091,896.31	9.20%	
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861.38	6.10%	76,801.45	0.60%	38,530.01	0.30%	115,331.46	1.00%	
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	2,323,573.26	19.50%	79,417.25	0.70%	2,103,184.98	17.70%	2,182,602.23	18.30%	
Нийт		11,915,760.30	100%	1,487,111.98	12.50%	3,211,991.47	27%	4,699,103.45	39.40%	

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдаж авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон компанийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зориулалтын дагуу үе шаттайгаар хэрэгжиж байгаа болно.

Тайлан бэлтгэсэн: Захиргаа, санхүүгийн газар